



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/406

Булган сум

**Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн
хэрэгжилтэд хяналт шалгалт хийх
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль, орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Булган аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрт Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн зөрчил гарч байгаа талаар иргэн Д.Туяагийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: С.Амар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: М.Хос-Эрдэнэ (Байгаль орчны газрын Хяналтын улсын байцаагч)

Ш.Мөнх-Амгалан (Цагдаагийн газрын Экологийн мөрдөгч, цагдаагийн ахмад)

Б.Март (Байгаль орчны газрын Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, хамгаалалт нөхөн сэргээлт, газар зүйн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн)

Х.Чинзориг (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

С.Сүхбаатар (Авто замын Хяналтын улсын байцаагч)

2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын танилцуулга, дүгнэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймгийн удирдлагуудад танилцуулахыг ажлын хэсэг (С.Амар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugaг Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010566